

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төвийн 2021 оны санхүүгийн тайлан, зорилтод түвшний гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/19/НА-СТА-ОНА

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Мөрөн хот

2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: : 261628 Цахим хаяг: [tegshee@audit.gov.mn](mailto:tegshee@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Эрдэнэчимэг

Утас: 99016320 Цахим хаяг: [erdenechimegg@audit.gov.mn](mailto:erdenechimegg@audit.gov.mn)

Ихэрмөрөн-аудит ХХК-ийн

Захирал: Ахлах аудитор Б.Мядагмаа

Утас: 99389208 Цахим хаяг: [b\\_myadagmaaa@yahoo.com](mailto:b_myadagmaaa@yahoo.com)

Аудитор: Д.Оюундаваа

Утас: 99389692 Цахим хаяг: [Oyuna\\_60@yahoo.com](mailto:Oyuna_60@yahoo.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан .....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан.....	5
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
а. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	8
3. Санхүүгийн тайлангийн тодруулга .....	10
3.1 Байгууллагын үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого.....	11
4. Аудитын тайлан .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Дотоод хяналт .....	14
4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	14
4.4 Материаллаг байдал.....	15
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	15
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
8. Аудитын илрүүлэлт.....	16
8.2 Төлбөрийн акт .....	17
Төлбөрийн акт тогтоогоогүй болно.....	17
8.3 Албан шаардлага .....	17
4 Зөвлөмж.....	18
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	20
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	0

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ОНӨХК	Орон нутгийн өмчит хувьцаат компани



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvs gul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2022.03.16 № 01/262  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

“ШИНЭ МӨРӨН ХУДАЛДААНЫ ТӨВ”  
ОНӨХК-ИЙН ЗАХИРАЛ Ц.НАЦАГДОРЖ  
ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Сангийн сайдын 2017 оны маягт заавар батлах тухай 347 дугаар тушаалаар батлагдсан бэлэн мөнгөн гүйлгээний тайлан гаргах НХМаягт-МХ-ийн дагуу 50\*100 цогцолборын тасалбарын орлого 11.8 сая төгрөгийн бэлэн мөнгөнд кассын тайлан гаргаагүй, НХМаягт-ТМ-4 ын дагуу 8.5 сая төгрөгийн шатахуунд жолоочийн тооцооны хуудас бүрэн бичиж тооцоо бодоогүй, томилолтоор ажилласан удирдамжгүй, томилолтын хуудас нь ирсэн буцсан тэмдэглээгүй хуудсаар 4.6 сая төгрөгийн томилолтын зардал олгосон, мөнгөн зарлагын 4.3 сая төгрөг е-баримтаар баталгаажгаагүй, зэрэг анхан шатны баримт бүрдэл дутуу 29.2 сая төгрөгийн ажил гүйлгээ байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйл 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалттай нийцээгүй иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 134.2 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс 124.9 төгрөгөөр давсан нь дангаараа эсвэл нийтээрээ санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.4 “нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах” гэж заасантай нийцээгүй байгаа нь нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон зүйл**

Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 01 тоот тогтоолоор Барилгын тендерийн баталгаанд байршиж буй 207.0 сая төгрөгийг барилгын чанаргүй гүйцэтгэлтэй ажлыг засварлах арга хэмжээнд зарцуулахыг зөвшөөрч, барилгын засварын ажил хийгдэж эхэлсэн байна.

## **Аудитын гол асуудлууд**

Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолоор өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг шалгахад бизнес төлөвлөгөөг 3 удаа тодотгол хийж элэгдлийн зардлаас бусад зардлыг 104.1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн, баяр ёслолын арга хэмжээнд 3.0 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь 1.6. “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол ... зэргийг; зохион байгуулахгүй байх” гэсэн заалтад нийцэхгүй байна.

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

### **Бусад асуудал**

Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төвийн ТУЗ-ийн 2021 оны 02 дугаар сарын 03 дугаар тогтоолоор 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа борлуулалтын орлогыг 453.7 сая төгрөг, нийт зардлыг 437.3 сая төгрөгөөр нийт ашиг 16.9 сая төгрөгөөр баталсан ба 2021 оны 6 дугаар сарын 30-ны 16 дугаар тогтоолоор тодотгол хийж орлогыг 90.1 сая төгрөгөөр бууруулж 363.6 сая төгрөг, зардлыг 111.6 сая төгрөгөөр нэмж 548.9 сая төгрөг, 185.3 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөгөө баталсан байна.

### **Бусад мэдээлэл**

“Шинэ мөрөн худалдааны төв” ОНӨХК нь 6000 м2 талбайтай бөгөөд үүнээс 3713.67 м2 ашигтай талбайд 270 лангуу, 12 бөөний төв 1 цайны газар ажиллаж байгаа бөгөөд давхардсан тоогоор 271 түрээслэгч бизнесийн үйл ажиллагаа явуулж байна. Талбайн түрээс зундаа 1м2 нь 10.0 мянган төгрөг буюу сарын борлуулалт дунджаар 35.0 сая төгрөг, өвөлдөө 1м2 нь 13.0 мянган төгрөгөөр буюу сарын борлуулалт дунджаар 43.0 сая төгрөг байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 16 өдөр

№ 31/АЭЭБ0434/ХӨА-2022/  
19/НА-СМА-ОАА

Мөрөн сум

### Зөрчил арилгуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн “Шинэ Мөрөн худалдааны төв” ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад 2021 оны 12 дугаар сард шинэ жилийн арга хэмжээ зохион байгуулж байгууллагын данснаас 3,065,000.0 / Гурван сая жаран таван мянга / хүлээн авалт, урлагийн тоглолтод зарцуулсан байна.


Энэ нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.6./ “Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн... зэргийг зохион байгуулахгүй байх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх, үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Засгийн газрын тогтоолоор өгсөн үүрэг чиглэлийг хэрэгжүүлж ажиллах, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь төрийн аудитын газар<sup>1</sup>-т ирүүлэх,
2. Цаашид Засгийн газрын тогтоол шийдвэрийг бүрэн хэрэгжүүлж алдаа, зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг “Шинэ Мөрөн худалдааны төв” ОНӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Нацагдорж, нягтлан бодогч Л.Долгор нарт даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

“ИХЭРМӨРӨН-АУДИТ” ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар 302 тоот, Утас: 7038-4043



## ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 16 өдөр

№ 32/А2260434/ХӨА-2022/  
19/НА-СТ.А-ОДА

Мөрөн сум

### Хариуцлага тооцуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн "Шинэ Мөрөн худалдааны төв" ХК-ийн 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:


Монгол Улсын ерөнхий аудиторын "Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай" 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад 245,604,417 /хоёр зуун дөчин таван сая зургаан зуун дөрвөн мянга дөрвөн зуун арван долоо/ төгрөгийн 48 мэдээллийг ил тод байршуулахаас, 171,300,000/нэг зуун далан нэгэн сая гурван зуун мянга/ төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй, 74,304,417/далан дөрвөн сая гурван зуун дөрвөн мянга дөрвөн зуун арван долоо/ төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.


Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1-т "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ" гэсэн заалтыг тус тус хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмын 4 дүгээр зүйлийн 4.2.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд "...Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлнэ." гэсэн заалтыг үндэслэн  
**ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны мэдээлэл хариуцсан ажилтанд Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулж, биелэлтийг 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т ирүүлэх;
2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй ажиллахыг "Шинэ Мөрөн худалдааны төв" ОНӨХК-ийн Гүйцэтгэх захирал Ц.Нацагдоржид даалгав.

### АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

"ИХЭРМӨРӨН-АУДИТ" ХХК-ИЙН  
ЗАХИРАЛ  Б.МЯДАГМАА

<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар  
302 тоот, Утас: 7038-4043

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Мөр дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 30	2021 оны 12-р сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	903,678.36	65,085,908.03
1.1.2	Дансны авлага	38,958,175.32	17,571,740.14
1.1.6	Бараа материал	21,945,819.91	27,285,830.19
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/Тооцоо	1,666,667.17	0
1.1.11	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>63,474,340.76</b>	<b>109,943,478.35</b>
1.2.1	Үндсэн хөрөнгө	5,321,273,103.96	5,701,398,259.37
1.2.2	Биет бус хөрөнгө	96,580,000.00	96,250,000.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,417,853,103.96	5,797,648,259.37
1.3	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>5,481,327,444.72</b>	<b>5,907,591,737.72</b>
2.1.1.1	Дансны өглөг	24,906,443.29	7,740,207.64
2.1.1.2	Цалингийн өглөг	128,416.61	1,257,811.66
2.1.1.3	Татварын өр	23,731,847.15	22,148,472.79
2.1.1.4	НДШ - ийн өглөг	9,215,714.48	0
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	44,100.00	160,000.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	58,026,521.54	31,306,492.09
2.2	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>58,026,521.54</b>	<b>31,306,492.09</b>
2.3	Эзэмшигчдийн өмч	0.00	0.00
2.3.1	Өмч: - төрийн	5,461,000,000.00	5,461,000,000.00
2.3.8	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	264,242,100.00	804,442,672.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(301,941,176.82)	(389,157,426.38)
2.3.11	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>5,423,300,923.18</b>	<b>5,876,285,245.62</b>
2.4	<b>Өр төлбөр ба эзэмшигчдын өмчийн дүн</b>	<b>5,481,327,444.72</b>	<b>5,907,591,737.72</b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		өмнөх он	Тайлант он
1	Борлуулалтын орлого (цэвэр)	331,768,622.67	443,231,866.20
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	0.00	0.00
3	Нийт ашиг (алдагдал)	331,768,622.67	443,231,866.20
4	Түрээсийн орлого	0.00	
5	Хүүний орлого	0.00	
6	Ногдол ашгийн орлого	0.00	
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	
8	Бусад орлого	0.00	
9	Борлуулалт, маркетингийн	0.00	

	зардал		
10	Ерөнхий ба удирдлагын зардал	466,007,195.85	528,905,687.59
11	Санхүүгийн зардал	457,785.49	0.00
12	Бусад зардал	0.00	0.0
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(109,090,833.33)	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(243,787,192.00)	(85,673,821.39)
19	Орлогын татварын зардал	0.00	0
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(243,787,192.00)	(85,673,821.39)

## 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	/төгрөгөөр/
				Нийт дү
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	5,461,000,000.00	264,242.100.00	-58,578,984.82	5,666,663,115.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			425,000.00	425,000.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	5,461,000,000.00	264,242.100.00	-58,153,984.82	5,667,088,115.18
Тайлант үеийн үр дүн			-243,787,192.00	-243,787,192.00
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	5,461,000,000.00	264,242.100.00	-301,941,176.82	5,423,300,923.18
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			-1,542,428.16	-1,542,428.16
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	5,461,000,000.00	264,242.100.00	-303,483,604.98	5,421,758,495.02
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт		540,200,572.00		540,200,572.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
Тайлант үеийн үр дүн			-85,673,821.40	-85,673,821.40

2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,461,000,000.00	804,442.672.00	-389,157,426.38	5,876,285,245.62
---------------------------------------	------------------	----------------	-----------------	------------------

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
6	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	371,915,097.73	506,241,844.00
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	371,915,097.73	506,241,844.00
1.2	Мөнгөн зарлага (-)	371,351,093.53	442,059,614.33
	Ажиллагчдад төлсөн	143,808,382.43	161,692,044.50
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн мөнгө	36,104,983.00	54,661,212.00
	Бараа материал худалдан авахад төлсөн	65,872,753.70	64,460,961.09
	Ашиглалтын зардалд төлсөн	96,881,527.67	92,084,038.08
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	3,020,000.00	9,916,500.00
	Хүүний төлбөрт төлсөн	454,585.49	0
	Татварын байгууллагад төлсөн	25,208,861.24	54,244,858.66
	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	5,000,000.0
	Бусад мөнгөн зарлага	0.00	
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	564,004.20	
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	
2.1	Үндсэн хөрөнгө худалдан авсан	0.00	
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	13,800,000.00	
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	13,800,000.00	
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	
	Ноогдол ашиг төлсөн	0.00	
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	13,800,000.00	
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	13,800,000.00	
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	564,004.20	64,182,229.67
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	339,674.16	903,678.36
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	903,678.36	65,085,908.03

## а. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

/төгрөгөөр/

№	Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК	2020 оны гүйцэтгэл	2021 оны батлагдсан төсөв	2021 жилийн эцсийн тайлан	Зөрүү	Хувь
2	<b>НИЙТ борлуулалтын орлого</b>	<b>331,768,622.67</b>	<b>387,197,544.6</b>	<b>443,231,866.2</b>	<b>(56,034,321.6)</b>	<b>14.4</b>
3	Нийт борлуулалтын орлого	331,768,622.20	387,197,544.6	443,231,866.2	(56,034,321.6)	14.47
5	<b>Нийт зардал</b>	<b>466,601,004.2</b>	<b>561,424,390.0</b>	<b>528,905,687.6</b>	<b>32,518,702.4</b>	<b>(5.7)</b>
6	Нийт цалингийн сан	144,204,255.00	165,385,800.0	164,977,916.0	407,884.0	(0.2)
7	НД-ын шимтгэл	18,532,877.70	22,243,500.0	21,254,838.1	988,661.9	(4.4)
8	ТУЗ зардал	19,946,043.20	22,956,500.0	22,609,032.7	347,467.3	(1.5)
9	Томилолтын зардал	2,423,000.0	7,064,000.0	5,568,168.6	1,495,831.4	(21.1)
10	Цахилгаан эрчим хүч	55,886,068.9	63,319,700.0	59,919,717.4	3,399,982.7	(5.3)
11	Дулаан эрчим хүчний зардал	14,775,348.20	16,079,000.0	15,552,542.6	526,457.4	(3.2)
12	Цэвэрлэгээ үйлчилгээ	4,160,054.60	8,111,500.0	3,935,435.5	4,176,064.5	(51.4)
13	Шуудан холбооны зардал	2,747,600.00	3,038,600.0	1,579,000.0	1,459,600.0	(48.0)
14	Ариутгалын зардал	4,214,000.0	5,531,000.0		5,531,000.0	(100.)
15	Цэвэр ус ашигласны төлбөр, бохир усны тээвэр	13,993,750.00	10,447,690.0	4,830,708.7	5,616,981.3	(53.7)
16	Хог хаягдлын зардал	1,093,700.00	1,816,700.0	1,472,100.0	344,600.0	(18.9)
17	Автомашин зардал	3,500,000.00	8,574,000.0	6,804,103.8	1,769,896.2	(20.6)
18	Бичиг хэрэг, офиссын зардал	3,571,767.90	5,883,000.0	5,727,668.3	155,331.7	(2.6)
19	Сургалтын зардал	1,162,800.00	920,000.0		920,000.0	(100)
20	Маркетингийн зардал	3,428,695.40	4,251,000.0	3,213,363.6	1,037,636.4	24.4
21	Аудит төлбөр		2,000,000.0	2,000,000.0	-	-
22	Хөдөлмөр хамгааллын зардал	2,188,836.90	5,261,600.0	5,219,693.9	41,906.1	(0.8)
23	Шагнал урамшуулал, нийгмийн халамжийн зардал	4,600,477.3	14,814,000.0	14,764,154.7	49,845.3	(0.3)
25	Засварын зардал	7,849,690.91	9,765,600.0	7,695,070.0	2,070,530.0	(21.2)
26	Үндсэн хөрөнгийн элэгдэл	138,006,220.70	156,524,900.0	176,094,749.6	(19,569,849.6)	12.5

27	Даатгалын зардал	4,999,999.50	5,103,000.0	-	5,103,000.0	(100.)
28	Газрын төлбөр	1,133,356.00	1,133,000.0	1,133,356.0	(356.0)	0.03
30	Хүүний зардал	454,585.5	0	0	0	0
31	50*100 Цогцолборын зардал	13,727,885.6	12,625,300.0	4,554,068.0	8,071,232.0	(63.9)
32	Соёмо цогцолборын зардал		8,575,000.0		8,575,000.0	(100.)

### 3. Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.1 Байгууллагын үйл ажиллагаа

Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн зорилго нь Орон нутгийн хөгжлийн хөтөлбөрт суурилсан бодлого төлөвлөлтийг боловсруулж, хамт олныг эерэг, зөв үйлээр удирдах менежментийг хөгжүүлэхэд оршино. Компанийн дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Худалдааны төвийн барилга байгууламжийн ашиглалтын менежментийг харилцан зохион байгуулах
- Тоног төхөөрөмж, өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн, үйлдвэрлэх, импортлох, экспортлох зэргээр гадаад дотоод худалдааг эрхлэх гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд 100% орон нутгийн өмчит хувьцаат компани гэсэн статустай байна.

#### 3.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК нь Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2017 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 125 дугаар тогтоолыг үндэслэн байгуулсан байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 “орон нутгийн өмчийн хуулийн этгээд байгуулах, өөрчлөн байгуулах, татан буулгах шийдвэр гаргаж, гүйцэтгэлд нь хяналт тавих” гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Хөвсгөл аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2021 оны 3 дугаар сарын 29 өдрийн 24 дүгээр тогтоолоор баталсан нь Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.7, 75 дугаар зүйлийн 74.4 дэх заалттай нийцэж байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” тогтоолын 1.3. “Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх;”-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийн орон тоог дөрвөөр нэмэгдүүлж, чиг үүргийн давхардлыг арилгах зорилгоор орлого бүрдүүлэгчийн 2 орон тоог 1 орон тоо болгон, тооцооны нягтлан бодогч, нярав, жолооч, харуул хамгаалалтын албаны дарга гэсэн орон тоо батлагдсан, цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан удирдлагын цалин хөлсийг 25 хувиар, ажилчдын цалинг 10 хувиар нэмэгдүүлж тогтоосон байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоол;
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр “Босго үнэ шинэчлэх тухай” тогтоол;
- Хөдөлмөрийн тухай хууль

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	903.7	65,085.9	64,182.2
БХХО	0	0	
Авлага	38,958.2	17,571.7	-21,386.4
Урьдчилгаа	1,666.6	0	-1,666.6
Бараа материал	21,945.8	27,285.6	5,340.0
Үндсэн хөрөнгө	5,321,273.1	5,701,398.2	379,795.1
Биет бус хөрөнгө	96,580.0	96,580.0	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>5,481,327.4</b>	<b>5,907,591.7</b>	<b>426,264.3</b>
Өр төлбөрийн дүн	0	0	
Богино хугацаат өглөг	58,026.5	31,306.5	-26,720.0
Урт хугацаат өглөг	0	0	0
Эздийн өмч	5,423,300.9	5,576,285.2	452,984.3
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>5,481,327.4</b>	<b>5,907,591.7</b>	<b>426,264.3</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, дансны авлага, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн дансанд материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Арилжааны банк дахь мөнгөний үлдэгдэлд харилцах дансанд 65.1 сая төгрөг болж өмнөх оноос 64.2 сая төгрөгөөр өссөн байна.

Авлага дансны үлдэгдэл 17.5 сая төгрөг болж 21.4 сая төгрөгөөр буурсан нь түрээслэгчдээс авах борлуулалтын авлага буурсан байна.

Авлагын дансны үлдэгдэлд төлөгдөх хугацаандаа байгаа 8.4 сая төгрөг, хугацаа хэтэрч шүүхийн шатанд шилжсэн 9.1 сая төгрөгийн авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 27.3 сая төгрөг болж 5.4 сая төгрөгөөр өссөн нь байгууллагын үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад зориулж бага үнэтэй түргэн элэгдэх бусад хангамжийн материалаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,797.6 сая төгрөг болж 379.8 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- Хөвсгөл аймгийн орон нутгийн өмчийн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 23 өдрийн А/135 тоот хөрөнгийг нэр төрлөөр бүртгэх тухай тушаалаар, өмнөх онд 800.0 сая төгрөгийн хөрөнгийн орлогыг задалж нэр төрлөөр орлого авах тухай зөвлөмж өгөгдсөний дагуу 20 нэр төрлийн хөрөнгийн задаргааг хийж 800.0 сая дээр 165.4 сая төгрөгийн хөрөнгийг нэмж орлого авсан байна.
- Хөвсгөл аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30 өдрийн 127 тоот хөрөнгө бүртгэх тухай тогтоолоор 374.7 сая төгрөгийн 5 нэр төрлийн хөрөнгийг орлого авсан байна.

- Тайлант онд 176.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал зэрэг тус тус нөлөөлсөн байна.

Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 31.3 сая төгрөг болж өмнөх оноос 26.8 сая төгрөгөөр буурсан байна. Энэ нэмэгдсэн өргийн албан татварын өр төлбөр, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр, байгууллагын хэвийн үйл ажиллагааг явуулахтай холбоотой гарсан зардлуудтай холбоотой үүссэн өр төлбөрүүд буурсан үзүүлэлттэй байна.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулалт маркетингийн болон ерөнхий удирдлагын зардал, үйл үйл ажиллагааны бус зардал, гэж ангилсан байна.

#### **3.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.38-д заасаны дагуу үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Хөвсгөл аймгийн Шинэ мөрөн худалдааны төвийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 03 дугаар тогтоолоор Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлахдаа борлуулалтын орлогыг 453.7 сая төгрөг, нийт зардлыг 437.3 сая төгрөгөөр нийт ашиг 16.9 сая төгрөгөөр баталсан ба 2021 оны 6 дугаар сарын 30-ны 16 дугаар тогтоолоор тодотгол хийж орлогыг 90.1 сая төгрөгөөр бууруулж 363.6 сая төгрөг, зардлыг 111.6 сая төгрөгөөр нэмж 548.9 сая төгрөг, 185.3 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөгөө баталсан байна.

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн ТУЗаас 2021 оны 12 дугаар сарын 15-ны 23 дугаар тогтоолоор дахин тодотгол хийж орлогыг 387.2 сая төгрөг, зардлыг 561,4 сая төгрөг болгон 174.3 сая төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөгөө баталсан байна.

Тайлант онд нийт зардлын дүнг 2 удаа тодотгохдоо цалингийн зардал 34.7 сая төгрөг, шагнал урамшуулал, нийгмийн халамжийн зардал 11.5 сая төгрөг, томилолтын зардал 6.8 сая төгрөг, үндсэн хөрөнгийн элэгдэл 20.0 сая төгрөг, эрчим хүч 17.8 сая төгрөг, бохир тээвэрлэх 10.0 сая төгрөг, бусад зардлуудад 23.3 сая төгрөг бүгд 124.1 сая төгрөгөөр нэмж баталсан байна.

Аймгийн ИТХ-ийн Тэргүүлэгчдийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны 127 дугаар тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж ашиглалтанд орсон нийт 374.7 сая төгрөгийн Соёмбо цогцолборыг байгууллагын орлого авч бүртгэсэнтэй холбоотой үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал нэмж батлагдсан байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд бохирын машин худалдан авах 8.0 сая төгрөг, иж бүрэн гэр 2,5 сая төгрөг, халуун усны душ 1.0 сая төгрөг, бусад 1.9 сая төгрөг нийт 13.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авахаар баталсан байна. Бохир соруулж тээвэрлэх зорилгоор 8.0 сая төгрөгийн хуучин Зил-130 машин худалдан авсан ба уг машин нь ашиглалтын шаардлага хангахгүй эвдэрч байгаа тул 2.1 сая төгрөгийн сэлбэг худалдан авсан байна.

Шинэ мөрөн худалдааны төвийн ТУЗ-ийн 2021 оны 08 дугаар сарын 06-ны өдрийн 19 дүгээр тогтоолыг үндэслэн өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглах зорилгоор бага оврын ачааны портер автомашин худалдан 7.7 сая төгрөгөөр худалдан авсан байна.

Гүйцэтгэлээр 443.2 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 528.9 сая төгрөгийн зардал гарган, 85.7 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Нийт орлогын гүйцэтгэл 443.2 сая төгрөг болж төлөвлөснөөс 56.0 сая төгрөг буюу 19.3 хувиар давсан нь худалдаа үйлчилгээний лангууг 100 хувь дүүргэн ажиллаж орлогыг нэмэгдүүлсэн байна.

Нийт зардлын гүйцэтгэл 528.9 сая төгрөг болж, төлөвлөснөөс 32.5 сая төгрөг буюу 5.8 хувиар хэмнэсэн гүйцэтгэлтэй байна. Энэ нь ариутгалын зардал 5.0 сая төгрөг, цэвэр бохир усны зардал 5.6 сая төгрөг, цэвэрлэгээ үйлчилгээний зардал 4.1 сая төгрөг, даатгалын зардал 5.0 сая төгрөг 50\*100 цогцолборын зардал 8.0 сая төгрөг, соёмбо цогцолборын зардал 8.5 сая төгрөг батлагдсан хэмжээнээс хэмнэж зарцуулсан байгаа нь гол нөлөө үзүүлсэн байна.

Тайлант онд цэвэр алдагдал 85.7 сая төгрөг болж, төлөвлөснөөс 88.5 сая төгрөгөөр буурсан нь, борлуулалтын орлого 56.0 сая төгрөгөөр төлөвлөснөөс давсан, зардал 32.5 сая төгрөгөөр хэмнэсэн байгаа нь нөлөөлж байна.

ТУЗ нь бизнес төлөвлөгөөг тодотгож батлахдаа, компаний үр ашгийг сайжруулах талаар бодлого баримтлаагүй, алдагдлыг хэмжээг нэмэгдүүлсэн төлөвлөгөө баталсан байна.

## 4. Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад, ТУЗ нь бизнес төлөвлөгөөг батлахдаа компаний үр ашгийг дээшлүүлэх талаар анхаарах, нягтлан бодох бүртгэлийн мэдээллийг нийгмийн даатгал, татварын цахим системд үнэн зөв мэдээлэх, шатахууны зардал, албан томилолтын зардалтай холбоотой анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, бэлэн мөнгөний кассын тайлан гаргах, е-баримтын бүрдлийг ханган ажиллах, авлагын үлдэгдлийг шийдвэрлэж ажиллахтай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Ихэрмөрөн-Аудит ХХК-ийн аудитор Д.Оюундаваа, аудиторын туслах П.Ундармаа нар гүйцэтгэж, чанарын хяналтыг, ахлах аудитор Б.Мядагмаа хэрэгжүүлж, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Б.Тэгшдэлгэр нар анхан шатанд, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар хоёр дахь шатны чанарын хяналтыг тус тус хэрэгжүүлсэн.

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан тодруулгыг тус байгууллагын гүйцэтгэх захирлын 2022 оны 02 дүгээр сарын 25-ны өдрийн 14 тоот албан бичгээр Ихэрмөрөн-Аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ирүүлсэн.

### 4.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө багатай байна гэж үзсэн.

Дотоод хяналтын нэгжийн чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод хяналтын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод хяналтаас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

#### 4.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Их” гэж үнэлэн материаллаг байдлын төвшинг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 466.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.3 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

##### 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК нь тайлант онд нийт 245.5 сая төгрөгийн 48 мэдээллийг ил тод байршуулахаас, 171.3 сая төгрөгийн 30 мэдээллийг мэдээлээгүй, 74.2 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 заалтад "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ." гэсэн заалтад нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, зөрчлийг давтан гаргасан тул хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлээ.

##### 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

ТБОНӨХБАҮХА тухай хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг, холбогдох хууль тогтоомжинд нийцсэн байна.

Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгахад шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээнд 3.0 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.6. "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

##### 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК-ийн санхүүгийн тайланд завсарын аудит хийгдээгүй болно.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 10.2 сая төгрөгийн 4 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, 835.8 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгснөөс, албан шаардлага 80 хувь, зөвлөмж 82.3 хувийн биелэлттэй байна.

**Хүснэгт 3.** Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт							
Албан шаардлага	4	10.2	3	10.2	1	0	20
Зөвлөмж	5	835.8	5	818.5	1	17.3	2.1
Нийт дүн	9	846.0	6	698.4	1	0	22.1

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 1 албан шаардлагын биелэлт хангагдаагүй давтан гаргаж байгаа асуудалд хариуцлагын албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Ашиглалтанд байгаа эд хөрөнгийг ажилтан бүрээр карт нээж бүртгэх, хөрөнгийн тооллогыг чанартай гүйцэтгэх, эд хариуцагч нярав нь бараа материалын тайлан гаргахдаа батлагдсан маягтын дагуу данс бүрээр тайланг гаргуулж ажиллах зэрэг асуудлуудад анхаарах шаардлагатай гэж үзлээ.

### 8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 531.3 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс, 147.9 сая төгрөгийн 9 алдааг залруулж, 248.6 сая төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 134.2 сая төгрөгийн 7 алдаа зөрчилд зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 134.2 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 9.3 сая төгрөгийн түвшинээс 128.5 сая төгрөгөөс их байгаа тул Хязгаарлалттай дүгнэлт өгөхөөр шийдвэрлэсэн болно.

#### 8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 147.9 сая төгрөгийн 9 алдааг залрууллаа. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлд, бараа материал үнэ бүхий зүйлийг орлого авахдаа хөрөнгийг ангилж бүртгээгүй бэлэн бүтээгдэхүүн дансанд 7.2 сая төгрөгийн засварын материал, машины сэлбэг хэрэгсэл, бичиг хэрэг, хангамжийн бараа материал, засварын материалуудыг орлого авсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4."үнэн зөв байх зарчим"-д нийцэхгүй, *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын хугацаанд залруулж ажилласан.
2. Орлогын тайланд элэгдлийн зардлыг 3.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.6."бүх зардал гэсэн" заалтад нийцэхгүй, *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул аудитын хугацаанд залруулж ажилласан.
3. Шүүхийн шийдвэрээр төлөгдсөн 2 түрээслэгчийн 0.1 сая төгрөгийн авлагыг нягтлан бодох бүртгэлд хаалтын бичилт хийгээгүй, 2 түрээслэгчийн жил дамнасан 0.7 сая төгрөгийн авлага нь павилон тохижуулалт вакуум хаалт хийгдсэн үндэслэлээр тооцоо нийлээгүй авлага барагдуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6."эд хөрөнгийн болон төлбөр

- тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх” ... гэсэн заалтад нийцэхгүй, *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул 0.1 сая төгрөгийн авлагыг залруулж ажилласан.
4. Нягтлан бодох бүртгэлд газрыг 2.9 сая төгрөгөөр элэгдүүлсэн, 96.2 сая төгрөгийн газрыг программ хангамж дансанд бүртгэсэн нь *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул алдааг залруулж зөв дансанд ангилж бүртгэж ажилласан.
  5. Нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг дансанд 0.2 сая төгрөгийн ер төлбөр нь тооцоо нийлсэн актаар нотлогдоогүй, байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх” .... *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул авлагыг залруулж ажилласан.
  6. Санхүүгийн тайлан тодруулгад тусгагдсан өр авлагын үлдэгдлийг тулгахад, 36 харилцагчийн 2.6 сая төгрөгийн авлага, 6 харилцагчийн 2.0 сая төгрөгийн тооцоог нийлж баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6.”эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтад нийцэхгүй, *Эрх ба үүрэг* батламж мэдэгдлийг хангахгүй тул аудитын хугацаанд тооцоо нийлж ажилласан.
  7. НӨАТ-д борлуулалтын орлогыг 8.9 сая төгрөгөөр дутуу тайлагнасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1.”Монгол Улсын нутаг дэвсгэрт борлуулсан бүх төрлийн бараа, ажил, үйлчилгээ” гэсэн заалтад нийцэхгүй, *Нийцсэн бөгөөд зохистой* байх батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулж ажилласан.
  8. 2021 онд 3 удаа Улаанбаатар хот болон бусад аймаг хотод томилолтоор ажиллахад олгосон 6.1 сая төгрөгийн баримтын бүрдүүлэлтийг шалгахад, томилолтоор ажиллуулах удирдамжгүй, байгууллагын холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй, томилолтоор ажилласан ажлын үр дүнгийн тайлан бичигдээгүй, томилолтын зардлын тооцоонд хамааралгүй баримт хавсаргасан, тооцоог бодоогүй байгаа нь *Нийцсэн бөгөөд зохистой* байх батламж мэдэгдлийг хангахгүй тул илүү олгосон томилолтын 1.4 сая төгрөгийг аудитын хугацаанд залруулж 1.1 сая төгрөгийн төлбөрийг барагдуулж 0.4 сая төгрөгийн авлага үүсгэж ажилласан.
  9. Орлого бүрдүүлэгчийн орлогын тайлан, Нягтлан бодох бүртгэлийн орлогын тайлангийн дүн 22.9 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнагдсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.”Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 20.1.1.”Нягтлан бодох бүртгэлийн анхан шатны баримт, холбогдох бусад баримт бичиг, мэдээ, мэдээллийг тогтоосон хугацаанд шаардан гаргуулах” гэсэн заалтад нийцэхгүй иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй тул орлого бүрдүүлэгчийн тайланг залруулж ажилласан.

## 8.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

## 8.3 Албан шаардлага

1. Монгол Улсын ерөнхий аудиторын “Шилэн дансны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналт хэрэгжүүлэх ерөнхий чиглэл батлах тухай” 2021 оны А/108 дугаар тушаалаар батлагдсан чиглэлийн дагуу шилэн дансны мэдээллийг шалгахад 245.5 сая төгрөгийн 48 мэдээллийг ил тод байршуулахаас, 171.3 сая төгрөгийн 30

мэдээллийг мэдээлээгүй, 74.2 сая төгрөгийн 18 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.1 заалтад "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ:" гэсэн заалтад нийцэхгүй *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2. Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолоор өгсөн үүрэг чиглэлийн хэрэгжилтийг шалгахад шинэ жилийн баяр ёслолын арга хэмжээнд 3.0 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын 1.6. "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам... зэргийг зохион байгуулахгүй байх" гэсэн заалтуудад нийцэхгүй, *Нийцсэн бөгөөд зохистой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### 4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. Анхан шатны баримт е-баримтаар баталгаажсан эсэх талаар.

1.1 Илрүүлэлт: Мөнгөн хөрөнгийн зарлагын 4.3 сая төгрөгийн гүйлгээ нь дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар дэмжигдээгүй байгаа нь Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 13.1.4. доор дурдсан бараа, ажил, үйлчилгээний зардал Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5. "заасан дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтаар ... баталгаажсан байх" гэсэн заалтад нийцэхгүй байгаа нь *Нийцсэн бөгөөд зохимжтой байх* батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Бараа материал үнэ бүхий зүйлийг худалдан авахдаа дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтын бүрдлийг ханган ажиллах.

##### 2. Цалингийн зардал Нийгмийн даатгалын шимтгэлийн зардалтай холбоотой.

2.1 Илрүүлэлт: Нийгмийн даатгалын цахим системийн мэдээллийн дүнг, нягтлан бодох бүртгэлийн цалин, шимтгэлтэй тулган баталгаажуулахад үндсэн цалингийн зардал 0.1 сая төгрөгийн зөрүүтэй, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 0.3 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. "үнэн зөв байх зарчим", 14 дүгээр зүйлийн 14.4.6. "бүх зардал" гэсэн заалтуудад нийцэхгүй байгаа нь *эрх ба үүрэг, Нийцсэн бөгөөд зохимжтой* байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Нийгмийн даатгалын цахим систем, төрийн албаны цалингийн нэгдсэн систем, цахим системийн мэдээллүүдийг нягтлан бодох бүртгэлийн мэдээлэлтэй тохируулж зөрүүгүй мэдээлэх.

##### 3. Кассын бэлэн мөнгөний тайлан гаргахтай холбоотой.

3.1 Илрүүлэлт: 50\*100 цогцолборын тасалбарын орлого 11.9 сая төгрөгийг бэлэн мөнгөөр авсан бөгөөд бэлэн мөнгөний кассын тайлан гаргаагүй байгаа нь Сангийн сайдын 2017 оны маягт заавар батлах тухай 347 дугаар тушаалаар батлагдсан 3.бэлэн мөнгөн гүйлгээний тайлан гаргах НХМаягт-МХ-4 гэсэн заалтад нийцэхгүй, "Иж бүрэн байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2 Өгсөн зөвлөмж: Бэлэн мөнгөн гүйлгээний тайланг бэлтгэх.

##### 4. Авлагын бүртгэлтэй холбоотой.

4.1 Илрүүлэлт: Хоёр түрээслэгчийн жил дамнасан 0.7 сая төгрөгийн авлага нь вакуум хаалт хийгдсэн үндэслэлээр тооцоо нийлээгүй авлага барагдуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6. "... бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж,

баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалтад нийцэхгүй, *Үнэлгээ ба хуваарилалт* батламж мэдэгдлийг хангахгүй тул шийдвэрлүүлж ажиллах.

4.2 **Өгсөн зөвлөмж:** Шийдвэр гаргах эрх бүхий газар, албан тушаалтнаар өр авлагыг шийдвэрлүүлж ажиллах.

## 5. Шатахууны зардалтай холбоотой.

5.1 **Илрүүлэлт:** Шатахууны тооцоог шалгахад Сангийн сайдын 2018 оны 2017 оны 3 дугаар сарын 5-ны 347 дугаар тушаалаар баталсан маягт зааварт заасан НХМаягт-ТМ-4 ын дагуу жолоочийн тооцооны хуудсаар бүрэн гаргуулаагүй, 8.5 сая төгрөгийн шатахууны тооцоог бодоогүй баримтын бүрдэл бүрэн хангагдаагүй. Дарга Нацагдоржийн хувийн машинд 2.3 сая төгрөгийн шатахуун авч зарцуулсан хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7. "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтад нийцэхгүй, *Нийцсэн бөгөөд зохистой* байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

5.2 **Өгсөн зөвлөмж:** Ажил үйлчилгээнд явсан тухай бүр жолоочийн тооцооны хуудсыг бүрэн гаргуулж ажиллах.

## 6. Томилолтын зардалтай холбоотой.

6.1 **Илрүүлэлт:** Шинэ мөрөн худалдааны төвийн захирал болон ажилтан нар нь 2021 онд 3 удаа Улаанбаатар хот болон бусад аймаг хотод томилолтоор ажиллахад олгосон 4.6 сая төгрөгийн баримтын бүрдүүлэлтийн шалгахад томилолтоор ажиллуулах удирдамжгүй, удирдамж, үнэмлэхийг байгууллагын холбогдох албан тушаалтнаар батлуулаагүй, томилолтоор ажилласан ажлын үр дүнгийн тайлан бичигдээгүй, томилолтын зардлын тооцоонд хамааралгүй баримт хавсаргах зэрэг анхан шатны баримтын бүрдэл хангагдаагүй байгаа нь Сангийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 27-ны 301 дугаар тушаалаар баталсан албан томилолтын зардалын хэмжээнд нийцээхгүй, *Нийцсэн бөгөөд зохистой* байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

6.2 **Өгсөн зөвлөмж:** Холбогдох хууль тогтоомж, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах.

## 7. Бизнес төлөвлөгөөтэй холбоотой.

7.1 Засгийн газрын 2021 оны 43-р тогтоолын хэрэгжилтийг шалгахад бизнес төлөвлөгөөг 3 удаагийн тодотгол хийж элэгдлийн зардлаас бусад зардлыг 104.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж бизнес төлөвлөгөөг алдагдалтай тодотгон баталсан нь Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуулийн 1-р хавсралт: Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2021 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн 15.1.3 "Төрийн өмчийн байгууллагын менежментийг сайжруулах, ашигтай ажиллуулах..." *Нийцсэн ба зохистой* байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

7.2 **Өгсөн зөвлөмж:** ТУЗ нь бизнес төлөвлөгөөг хянаж батлахдаа үр ашгийг дээшлүүлэхэд анхаарч холбогдох хууль тогтоомжыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

д/ д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөри йн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал											
1	Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК	17	285.3	9	147.9	-	-	1	3.0	7	134.2
Дүн		17	285.3	9	147.9	-	-	1	3.0	7	134.2
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал											
1	Шинэ мөрөн худалдааны төв ОНӨХК	1	245.6					1	245.6		
Дүн		1	245.6					1	245.6		
Нийт дүн		18	531.3	9	147.9			2	248.6	7	134.2

БАТАЛГААЖУУЛАХ ХЭСЭГ:

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРААС

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР Огноо:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

Б.ТЭГШДЭЛГЭР Огноо: 3.15

АХЛАХ АУДИТОР

Г.ЭРДЭНЭЧИМЭГ Огноо:

ИХЭРМӨРӨН-АУДИТ ХХК

ХЯНАСАН: АУДИТОР

Б.МЯДАГМАА Огноо:

БОЛОВСРУУЛСАН: АУДИТОР

Д.ОЮУНДАВАА Огноо

